

## Нууцлалын бодлого

### 1. Оршил

Энэхүү "Нууцлалын бодлого" нь Ус сувгийн удирдах газрын "УСУГ" Засвар үйлчилгээний программийн систем болон апплэйшн нь хэрэглэгчийн ямар мэдээллийг хэрхэн боловсруулж ашиглах тухай тодруулга ойлголтыг өгөх болно.

### 2. Хэрэглэгчийн ямар мэдээллийг хадгалах вэ ?

"УСУГ" Засвар үйлчилгээний программийн апплэйшнг ашиглахдаа байгууллагын үндсэн хөрөнгийг үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөөлөх байдлаар нь зэрэг тогтоож /1,2,3/ мөн нөхцөл байдлаар /A,B,C/ ангилснаар хөрөнгийн нөхцөл байдлын үнэлгээ хийх, хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг үнэн зөв бодитоор боловсруулах, гэмтэл саатлын мэдээллийг оруулахад дэмжлэг болох юм.

### 3. Мэдээлэл цуглуулах ашиглах

"УСУГ" Засвар үйлчилгээний программын апплэйшнг ашиглан мэдээлэл цуглуулахдаа хэрэглэгчийн өөрийн эрхээр орж гэмтлийн мэдээлэл болон үндсэн хөрөнгийн бүртгэлтэй мэдээллүүд дээрийн засвар үйлчилгээний талаар, техник ашиглалтын паспортын бүртгэлийн мэдээллүүд оруулна.

### 4. Мэдээлэл хуваалцах болон түгээх

Улаанбаатар хотын Ус сувгийн удирдах газрын станц цэг салбар, инженерийн дэд бүтцийн нэгдсэн хяналт нь байгууллагын зөвшөөрөлгүйгээр гуравдагч этгээдэд хуваалцаж түгээхгүй ба "Нууцлалын бодлого"-д тусгаснаас өөр зорилгоор ашиглахгүй болно.

### 5. Мэдээллийн аюулгүй байдлын хамгаалалт

5.1 "УСУГ" Засвар үйлчилгээний программын администратор эрхтэй хэрэглэгч нь байгууллагын удирдлагын албан ёсны шийдвэрийн дагуу мэдээллийг өөрчлөх бөгөөд үндэслэлгүйгээр мэдээлэл үүсгэх, өөрчлөх, устгах болон худал мэдээлэл оруулахыг хориглоно.

5.2 Программын хэрэглэгч нь өөрийн нэвтрэх нэр, нууц үгийг бусдад шилжүүлэхийг хориглох ба эрхээ шилжүүлснээс үүсэх үр дагавар нь хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.

5.3 “УСУГ” Засвар үйлчилгээний программд агуулсан мэдээллүүд төрийн болон албаны, байгууллагын нууцын зэрэглэлийн мэдээллийг агуулсан тул уг программыг ашиглах эрх бүхий ажилтнууд нь ажил, үүргийнхээ дагуу олж авсан мэдээллийг хувийн болон бусад зорилгоор ашиглах, бусдад дамжуулах, задруулахыг хориглоно.

#### 6. Нууцлалын бодлогод өөрчлөлт оруулах

Ус сувгийн удирдах газар нь энэхүү нууцлалын бодлогод өөрчлөлт оруулах бүрэн эрхтэй ба өөрчлөлт орсон тухай бүрд <https://usug.ub.gov.mn/> цахим хуудсанд байршуулна. Тиймээс нууцлалын бодлогыг тогтмол шалгахыг зөвлөж байна. Өөрчлөлт, тодруулга нь цахим хуудас дээр нийтлэгдсэнээс хойш хүчин төгөлдөр байна.

#### 7. Холбоо барих

Нууцлалын бодлогын талаар асууж тодруулах, нэмэлт саналууд гарвал <https://usug1959@gmail.com/> цахим шуудангийн хаяг, +976 70157015 утасны дугаараар холбоо барина уу.